



МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн
Гаалийн ерөнхий газрын дэргэдэх
Салбар зөвлөлийг байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Монгол Улсын Их хурлын 2019 оны 02 дугаар сарын 1-ний өдрийн 17 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 5.11, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга:	Р.Отгонжаргал	Гаалийн ерөнхий газрын дарга
Гишүүд:	Я.Эрдэнэчимэг	Гаалийн ерөнхий газрын Тариф, татварын газрын дарга
	Ж.Эрдэнэболд	Гаалийн ерөнхий газрын Зөрчилтэй тэмцэх, аюулгүй байдлын газрын дарга
	Л.Очгэрэл	Гаалийн ерөнхий газрын Дотоод хяналт шалгалтын хэлтсийн дарга
	Э.Лхагвасүрэн	Гаалийн ерөнхий газрын Статистик, дүн шинжилгээний хэлтсийн дарга
	Ө.Цолмон	Гаалийн ерөнхий газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга
Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга:	Ч.Чимэд-Очир	Гаалийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн Гаалийн улсын байцаагч

2."Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж,Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүй хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн удирдлагаар ханган, Салбар зөвлөлийн үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга /Р.Отгонжаргал/-д үүрэг болгосугай.

3.Салбар зөвлөлийг удирдлагаар хангаж, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж буй байдалд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга (Г.Билгүүн)-д даалгасугай.

ДАРГА

Б.БААТАРЗОРИГ

БАТЛАВ
 ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ГААЛИЙН
 ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ САЛБАР
 ЗӨВЛӨЛИЙН ДАРГА - Р.ОТГОНЖАРГАЛ



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ	Ажил үйлчилгээ	Хугацаа	Тоо, чанар, гүйцэтгэлийн шалгуур	Хариуцах гишүүн
Бэлтгэл ажлын хүрээнд					
1	Салбар зөвлөлийн гишүүдэд холбогдох хууль, журмын хуулбарыг хавтаст хийж хүлээлгэн өгөх	Холбогдох хууль, журмын жагсаалтыг гаргах, хувилах хавтасжуулах	5 сард	Салбар зөвлөлийн гишүүдэд холбогдох хууль, журмыг хувиран хавтасжуулан тараасан байна.	СЗ-ийн нарийн бичгийн дарга
2	Салбар зөвлөлийн гишүүдээр нууцлалын баталгаа болон Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргуулах	Холбогдох хууль, журамд нийцүүлэн баталгаа, мэдэгдэл гаргуулах	5 сард	Баталгаа, мэдэгдэл гаргуулсан байна.	СЗ-ийн нарийн бичгийн дарга
3	Салбар зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг гаргах	Салбар зөвлөлийн гишүүд тус бүрээр хариуцах ажил үүргийн хуваарийг тодорхойлох	5 сард	Гишүүдийн ажил үүргийн хуваарь батлагдсан байна.	СЗ-ийн нарийн бичгийн дарга

4	Салбар зөвлөлийн хурлын дэгийг боловсруулах	Салбар зөвлөлийн хурлын дэгийг боловсруулах	5 сард	Хурлын дэг батлагдсан байна.	СЗ-ийн нарийн бичгийн дарга
5	Салбар зөвлөлийн төсвийн төслийг боловсруулах	Салбар зөвлөлийн зөвлөлийн үйл ажиллагааны төсөв, эдийн засгийн тооцоог боловсруулах	5 сард	Төсөв батлагдсан байна.	Санхүү, хөрөнгө оруулалтын газар
6	Салбар зөвлөлийн тэмдэг, албан бланк /хуралдааны тогтоол, тэмдэглэл/ захиалах	Салбар зөвлөлийн тэмдэг, албан бланкны загварыг батлуулж захиалга өгөх	5 сард	Салбар зөвлөлийн тэмдэг, албан бланк бэлэн болсон байна.	СЗ-ийн нарийн бичгийн дарга
7	Салбар зөвлөлийн хурлыг хуралдуулах	Салбар зөвлөлийн хурлыг зохион байгуулж, хуралдааны тэмдэглэл, гарсан шийдвэрийг албажуулах	5 сард	Салбар зөвлөлийн хуралдааны шийдвэрийг албажуулж, хэрэгжүүлсэн байна.	СЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга
8	Сонгон шалгаруулалт явуулах	<ul style="list-style-type: none"> -захиалгыг хүлээн авах -товыг тодорхойлох -комисс байгуулах -ТАЗ-ын цахим хуудас, Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим хуудсаар мэдээлэх -ГЕГ-ын цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр зар тавих - Сонгон шалгаруулалтын бүртгэлийг зохион байгуулах - Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах - Сонгон шалгаруулалтын тайланг нэгтгэн, шалгалтад тэнцсэн иргэдийг нөөцөд бүртгүүлэх 	5 сард	Сонгон шалгаруулалт зохион байгуулагдаж нэр дэвшигчид томилогдсон байна.	СЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, комиссын дарга, гишүүд

		саналыг ТАЗ болон ТАЗСЗ-д хүргүүлэх -Шалгалтад тэнцсэн оролцогчдоос онооны дараалыг баримтлан томилуулахаар нэр дэвшүүлэх -Нэр дэвшигчийг ТАЗ, ТАЗСЗ-ийн тогтоолын дагуу томилуулах		
Үндсэн ажлын хүрээнд				
1	Төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого, үзэл баримтлалыг төрийн албан хаагч болон олон нийтэд танилцуулах, сурталчилах	Харьяа гаалийн газар хороодод хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үйл ажиллагааг зохион байгуулахад мэргэшлийн зөвлөгөө, арга зүйн туслалцаа үзүүлэх	Жилдээ	Харьяа гаалийн газар хороодод зөвлөгөө, зөвлөмж хүргүүлсэн байна.
2	Төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх ажлыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан заавар, аргачлалын хүрээнд зохион байгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх	Төрийн албаны зөвлөлийн шийдвэр, өгсөн үүргийн хэрэгжилтийг зохион байгуулах	Тухай бүрт нь	Үүрэг даалгаврыг хугацаанд нь хүргүүлсэн байна.
3	ТАЗ-ийн 2019оны 17 дугаар тогтоолоор батлагдсан хүний нөөц бүрдүүлэх журмын хэрэгжилтыг зохион байгуулах	ТАЗ-ийн 2019оны 17 дугаар тогтоолын дагуу гаалийн байгууллагын төрийн албан хаагчийн болон анх орох иргэний нөөцийн санг бүрдүүлэх, бүртгэлийг хөтлөх	Жилдээ	Нөөцийн санг бүрдүүлж, тайлан, мэдээг ТАЗ-д хүргүүлсэн байна.
4	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаанд хяналт тавьж ажиллах	Жилдээ	Хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцсон байна.
5	Гаалийн байгууллагын "Сэлгэн ажиллах журам"	Гаалийн байгууллагын "Сэлгэн ажиллах журам" шинэчлэн боловсруулж, батлуулах	2-р улиралд	Журмыг шинэчилж үйл ажиллагаандаа

				хэрэгжүүлж эхэлсэн байна.	нарийн бичгийн дарга
6	Гаалийн байгууллагын "Хүний нөөцийн ойрын болон урт хугацааны төлөвлөлт"	Гаалийн байгууллагын "Хүний нөөцийн ойрын болон урт хугацааны төлөвлөлт" боловсруулж, батлуулах	2-р улиралд	Төлөвлөлтийг батлуулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхэлсэн байна.	СЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга
7	Маргааныг хянан шийдвэрлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах	ТАЗ, ТАЗСЗ-д ГУБ болон иргэдээс ирүүлсэн гомдол, маргааныг хянан шийдвэрлэх	Тухай бүрт нь	Маргааныг хянан шийдвэрлэж тайланг ТАЗ-д хүргүүлсэн байна.	СЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга
8	Хуульд заасны дагуу томилох эрх бүхий этгээдийн баталсан Албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан тусгай шаардлагад нийцүүлэн хянах	Албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан тусгай шаардлагад нийцүүлэн батлуулах	Жилдээ	Албан тушаалын тодорхойлолтыг хянан батлуулсан байна.	СЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга
9	Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартын зөрчлийг арилгуулах талаар шат дараалсан арга хэмжээ авах	Харьяа гаалийн газар хороодод төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартын зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж хүргүүлэх	Тухай бүрт нь	Зөвлөмж хүргүүлсэн байх.	СЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга
10	Сонгон шалгаруулалт явуулах захиалгыг хүлээн авах, хянах, зарлуулах	Сонгон шалгаруулалт явуулах захиалгыг хүлээн авах, хянах, зарлуулах ажлыг зохион байгуулах	Тухай бүрт нь	Сонгон шалгаруулалт явуулж, тайланг ТАЗ-д хүргүүлсэн байна.	СЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга
11	Салбар зөвлөлийн хурлыг зохион байгуулах	Салбар зөвлөлийн хурлыг зохион байгуулж, хуралдааны тэмдэглэл, гарсан шийдвэрийг албажуулах	Тухай бүрт нь	Хуралдааны шийдвэрийг албажуулж, хэрэгжүүлсэн байна.	СЗ-ийн нарийн бичгийн дарга

12	Төрийн албаны зөвлөлийн "Цахим хуудас"-аар Салбар зөвлөлийн үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтэд ил тод нээлттэй хүргэн сурталчилах, холбогдох мэдээллийг байршуулах ажлыг зохион байгуулах	Төрийн албаны зөвлөл болон Гаалийн Ерөнхий газрын цахим хуудсаар Салбар зөвлөлийн үйл ажиллагааг нээлттэй сурталчилах	Тухай бүрт нь	Мэдээ, мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байна.	СЗ-нар бич да
13	Салбар зөвлөлийг чадавхижуулах чиглэлээр Сангийн яам болон Төрийн албаны зөвлөлтэй хамтран ажиллах	Төрийн албаны зөвлөл болон бусад байгууллагаас зохион байгуулах сургалт, семинарт СЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргыг хамруулах	Тухай бүрт нь	Сургалтад хамрагдсан байна.	СЗ-дар гиш нар бич да

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ